



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/34

Улаан-Уул

Бүх нийтийн их цэвэрлэгээ  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, 9.5.2, 10 дугаар зүйлийн 10.2.6, 10.2.10 дахь заалт, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.4 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан, цас хайлж гудамж, нийтийн эзэмшлийн талбай хог хаягдал ил гарч сумын өнгө үзэмж цаашлаад иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа тул Худаг-Урт 4 дүгээр багийн төвөөс Хар хошуу хүртэлх 53 км улсын чанартай авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр, нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр тус тус зохион байгуулсугай.

2. Сумын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэх баталсан хуваарийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага цэвэрлэгээний ажлыг чанартай зохион байгуулахыг аж ахуйн нэгж, албан байгууллагын дарга, эрхлэгчид, Хөрш-Айлын ахлагч нар, 6 дугаар багийн Засаг дарга (Г.Нямдаваа), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтыг улсын байцаагч (Т.Мөнхжаргал), Байгаль хамгаалагч (Ж.Машбат) нарт үүрэг болгосугай

3. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдорж)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201035